


2013

**ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ,
АЖИЛГҮЙДЛИЙН
БАЙДЛЫН ТАЛААРХИ
ТАНИЛЦУУЛГА**
/2012 онд/

Ж.Эрдэнэсүрэн
Увс аймгийн Статистикийн хэлтэс
11/24/2013



Хүн амын ажил эрхлэлт, ажилгүйдлийн талаархи мэдээллийг 2006 оноос өмнө засаг захиргааны мэдээлэлд тулгуурлан, бүртгэл явагдаж буй цан хугацаагаар, өрх, хүн амын бүртгэлийг үндэслэн гаргаж ирсэн. Энэхүү бүртгэл судалгаа нь жилд нэг удаа гардаг, жилийн дундаж өөрчлөлтүүдийг харуулдаггүй, ялангуяа улирлын хэлбэлзлэлийг тооцож бодлого төлөвлөлтөнд ашиглах боломжийг бүрдүүлдэггүй, мэдээллийн чанарын шаардлага хангагдахгүй байгаа зэрэг шалтгааны улмаас ажил эрхлэлтийн байдлыг түүвэр судалгааны аргаар судалж тогтоож байна.

Үндэсний Статистикийн Хорооны дарга, НХХ-ийн сайдын 2009 оны 01-68/94 тоот хамтарсан тушаалаар баталсан “ Хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал- д тусгагдсан ойлголт, тодорхойлолт, ҮСХ-ны баталсан маягт, аргачлал, зааврыг судалгаанд ашиглаж байгаа юм.

Эдийн засгийн идэвхийг сүүлийн 7 хоногийн байдлаар буюу тухайн үеийн идэвхи, сүүлийн 12 сарын байдлаар буюу байнгын идэвхээр тооцож, сүүлийн 7 хоногт ядаж 1 цаг цалин, орлоготой ажил эрхэлсэн хүнийг ажил эрхэлдэг гэж үзсэн бөгөөд өвчтэй, жирэмсний болон төрсний дараахь чөлөөтэй, ээлжийн амралттай, зэрэг шалтгаанаар сүүлийн 7 хоногт ажил эрхлээгүй боловч үндсэн байгууллага, аж ахуйн нэгжтэйгээ хөдөлмөрийн гэрээгээ цуцлаагүй хүмүүсийг ажил эрхэлдэг гэж үзсэн.

Сүүлийн 7 хоногт ажил эрхлээгүй бөгөөд хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэст бүртгэлтэй болон бүртгэлгүй, ажил идэвхитэй хайж байгаа, ажиллахад бэлэн хүнийг хамруулж ажилгүйчүүдийг тооцсон.

Ажиллах хүчинд ажил эрхэлдэг хүн, ажилгүй иргэдийг хамруулж байгаа бөгөөд энэ нь цаашдаа улс, аймгийн нийгэм, эдийн засаг, ялангуяа ажиллах хүчний бодлого төлөвлөлтөнд чухал ач холбогдолтой мэдээлэл болох юм.

Ажиллах хүчний 2012 оны түүвэр судалгаанд Зүүнговь / Зэлийн гол /, Наранбулаг / Алдар-2 удаа /, Хяргас / Дэлгэр-2 удаа /, Өмнөговь / Улиаст, Намир /, Улаангом / 4, 5, 6, 7, 6, 7, 9, 10, 10, 7, 11, 4 / Өлгий / Өлгий нуур /, Цагаанхайрхан / Хунт /, Малчин / Баянхайрхан, Баянэрдэнэ /, Тэс / 6, 11, 1 /, Өндөрхангай / Цэцэрлэг /, Тариалан / Хөхөө, /, Давст / Торхилог/, Завхан / Шар булаг /, Ховд / Халиунбулаг, Ачит /, Зүүнхангай / Хайрхан/ сум, багуудын 384 өрх судалгаанд хамрагдаж өрхийн тоо өнгөрсөн оноос 6,1 хувиар өссөн байна.

Судалгаанд хамрагдах сум, баг, өрхийг ҮСХ-оос сонгодог бөгөөд сум, баг, өрх нь сар бүр өөрчлөгдөж байхаар сонгодог. Өрхүүдийг сонгохдоо энгийн санамсаргүй түүврийн аргыг ашиглан сонгож ҮСХ-оос нэрсийг нь явуулдаг бөгөөд харин судлаач нар санамсаргүй сонгогдсон өрхийг өөрчлөн өөр өрх сонгон мэдээлэл авах боломжгүй байдаг.


УВС АЙМАГТ ЯВАГДАЖ БУЙ “ АЖИЛЛАХ ХҮЧ” - НИЙ ТҮҮВЭР СУДАЛГААНЫ 2012 ОНЫ ҮНДСЭН ҮР ДҮН

2012 оны эцэст УВС аймагт 37,9 мянган эдийн засгийн идэвхитэй хүн ам байгаа бөгөөд энэ нь 2011 оны мөн үеэс 7,1 хувиар, 2010 оны мөн үеэс 2,1 хувиар, 2009 оныхоо 10,0 хувиар бага байна. Ажиллах хүчний оролцооны түвшин 77,2 хувьд хүрч өмнөх 3 жилийн дунджаас 4,4 пунктээр бага байна. АХОТ улсын дунджаар 63,5 хувьтай байгаа бөгөөд тус аймгийн АХОТ улсын дунджаас 13,7 пунктээр илүү байна.

ХҮН АМЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, ОНЫ ЭЦЭСТ

	2009	2010	2011	2012
15 ба түүнээс дээш насны хүн амын тоо, мян. хүн	49,2	50,9	49,1	49,1
Эдийн засгийн идэвхитэй хүн амын тоо, мян. хүн	42,1	38,7	40,8	37,9
Ажиллагсадын тоо, мян. хүн	38,8	32,9	36,6	34,7
Ажилгүй иргэдийн тоо, хүн	3277	5787	4225	3177
Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо	2252	1230	781	1002
Эдийн засгийн идэвхигүй хүн амын тоо, мян. хүн	11,6	12,9	11,4	10,3
Ажиллах хүчний оролцооны түвшин, хувь	85,6	76,0	83,1	77,2
Хөдөлмөр эрхлэлтийн түвшин, %	92,2	85,0	89,7	91,6
Ажилгүйдлийн түвшин, хувь	7,8	15,0	10,4	8,4
Улсын дундаж ажилгүйдлийн түвшин, %	11,6	9,9	7,7	8,2

Хөдөлмөр эрхлэлтийн түвшин 91,6 хувьд хүрч улсын дунджаас 0,2 пунктээр бага, өнгөрсөн оны мөн үеэсээ 1,9 пунктээр өссөн байна.



Эдийн засгийн идэвхитэй хүн ам гэдэгт 2012 онд бүтээгдэхүүн, үйлчилгээг үйлдвэрлэхэд ажиллах хүчээ нийлүүлж байгаа ажиллагсад, нийлүүлэхэд бэлэн байгаа ажилгүйчүүдийг хамааруулах бөгөөд ЭЗИХА-ын бууралтын дийлэнх нь ажилгүй иргэдийн тооны бууралтаас шалтгаалсан байна.

15 БА ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХИТЭЙ
ХҮН АМЫН ТОО, бүс, аймаг, нийслэлээр, оны эцэст

Аймаг	мян. хүн			
	2009	2010	2011	2012
БҮГД	1137,9	1147,1	1124,7	1151,1
Баруун бүс	188,6	187,9	188,2	196,9
Баян-Өлгий	43,9	43,3	45,2	51,4
Говь-Алтай	29,3	31,0	27,4	30,4
Завхан	32,8	39,0	36,8	40,0
Увс	42,1	38,7	40,8	37,9
Ховд	40,5	35,9	38,0	37,2
Хангайн бүс	268,8	268,3	253,4	273,7
Архангай	47,4	49,4	49,2	49,6
Баянхонгор	37,9	37,6	36,3	38,6
Булган	27,7	30,7	28,7	29,6
Орхон	41,2	37,7	37,2	41,7
Өвөрхангай	57,7	54,5	48,0	54,3
Хөвсгөл	56,9	58,4	56,9	59,9
Төвийн бүс	215,6	215,4	214,1	197,4
Говьсүмбэр	6,1	5,8	5,6	3,4
Дархан-Уул	40,4	39,0	40,2	37,5
Дорноговь	25,3	29,2	21,4	23,6
Дундговь	24,1	24,2	24,4	23,4
Өмнөговь	27,3	27,7	28,9	21,5
Сэлэнгэ	50,1	47,1	45,7	41,1
Төв	42,3	42,4	47,9	46,9
Зүүн бүс	76,9	80,4	86,2	89,8
Дорнод	24,3	26,2	28,9	27,6
Сүхбаатар	28,9	30,5	28,6	30
Хэнтий	23,7	23,7	28,7	32,2
Улаанбаатар	388	395,1	382,8	393,3

* " Ажиллах хүчний түүвэр судалгаа" - аар тооцож гаргав.

2012 оны эцэст УВС аймагт 34,7 мянган ажиллагсад байгаа бөгөөд энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 5,2 хувиар, сүүлийн 3 жилийн дунджаас 3,8 пунктээр буурсан байна.

Эдийн засгийн салбаруудад ажиллаж буй ажиллагсадын тоогоор баруун аймгуудаас 3-т тооцогдож, баруун бүсийн ажиллагсадын 19,5 хувь нь тус аймагт ноогдож, өнгөрсөн оноос 2,3 пунктээр бага байна.

Улсын хэмжээний ажиллагсадын 3,3 хувь нь Увс аймагт ноогдож байгаа бөгөөд 17,6 мянган эрэгтэй, 17,2 мянган эмэгтэй ажиллагсад байна.

АЖИЛЛАГСАДЫН ТОО, бүс, аймаг, нийслэлээр, оны эцэст

Аймаг	мян. хүн			
	2009	2010	2011	2012
БҮГД	1006,3	1033,7	1037,7	1056,4
Баруун бүс	174,5	169	167,8	177,6
Баян-Өлгий	40,2	42,1	42,0	45,1
Говь-Алтай	27,4	28,2	24,4	26,3
Завхан	31,5	33,2	30,1	37,3
Увс	38,8	32,9	36,6	34,7
Ховд	36,6	32,6	34,7	34,2
Хангайн бүс	236,6	236,4	232,3	251,1
Архангай	44,0	46,0	47	48,0
Баянхонгор	37,8	36,3	34,5	37,3
Булган	24,0	26,1	24,9	26,9
Орхон	29,2	28,0	32,8	35,7
Өвөрхангай	53,6	51,7	44,0	52,4
Хөвсгөл	48	48,3	49,1	50,8
Төвийн бүс	191,4	195,4	199,5	182,2
Говьсүмбэр	4,8	5,0	5,3	3,2
Дархан-Уул	34,1	34,7	36,8	32,1
Дорноговь	20,1	24,6	20,2	22,7
Дундговь	20,9	21,8	22,3	21,4
Өмнөговь	23,2	23,4	24,5	20,0
Сэлэнгэ	48,8	46,1	45,1	38,6
Төв	39,5	39,8	45,3	44,2
Зүүн бүс	70,0	72,0	76,7	80,2
Дорнод	23,7	23	25,8	25,4
Сүхбаатар	24,3	26,3	24,7	26,8
Хэнтий	22,0	22,7	26,2	28
Улаанбаатар	333,8	391,9	361,4	365,3

АЖИЛЛАГСАДЫН ТОО, хүйсээр, бүс, аймаг, нийслэлээр, оны эцэст

Аймаг	Б Ү Г Д		Х Ү Й С Э Э Р	
	Тоо	%	Эрэгтэй	Эмэгтэй
Архангай	47965	4,5	24089	23876
Баянөлгий	45068	4,3	23713	21355
Баянхонгор	37245	3,5	19459	17786
Булган	26902	2,5	13823	13079
Говь-Алтай	26258	2,5	13703	12555
Дорноговь	22735	2,2	12725	10010
Дорнод	25397	2,4	12432	12965
Дундговь	21435	2,0	10767	10668
Завхан	37347	3,5	19514	17833
Өвөрхангай	52429	5,0	28527	23902
Өмнөговь	20045	1,9	10398	9647
Сүхбаатар	26756	2,5	13479	13277
Сэлэнгэ	38587	3,7	20858	17729
Төв	44148	4,2	23652	20496
Увс	34723	3,3	17573	17150
Ховд	34200	3,2	18538	15662
Хөвсгөл	50833	4,8	26196	24637
Хэнтий	28051	2,7	13808	14243
Дархан-Уул	32079	3,0	17045	15034
Улаанбаатар	365287	34,6	190178	175109
Орхон	35728	3,4	18112	17616
Говьсүмбэр	3223	0,3	1721	1502
ДҮН %		100,0		
Улсын дүн	1056441		550310	506131

2012 оны эцэст УВС аймагт 15- аас дээш насны, ажил хөдөлмөр эрхлээгүй, ажил хөдөлмөр эрхлэхэд бэлэн байсан, ХХҮХ-т бүртгүүлж болон бүртгэлгүйгээр ажил хайсан, ажил эрхлэх боломжтой 3,2 мянган ажилгүйчүүд байгаа бөгөөд энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 1000 хүнээр буюу 23,8 хувиар буурсан байна.

Ажилгүй иргэдийн тоо сүүлийн 3 жилийн дунджаас 1,2 мянган хүнээр буюу 27,3 хувиар буурсан байна. Баруун бүсийн ажилгүйчүүдийн 16,6 хувь нь тус аймагт ноогдож байна.

15 БА ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО,
бүс, аймаг, нийслэлээр, оны эцэст

Аймаг	мян. хүн			
	2009	2010	2011	2012
БҮГД	131,6	113,4	87,0	94,7
Баруун бүс	14,1	18,9	20,3	19,3
Баян-Өлгий	3,7	1,2	3,2	6,4
Говь-Алтай	1,9	2,8	3,0	4,2
Завхан	1,3	5,8	6,7	2,5
Увс	3,3	5,8	4,2	3,2
Ховд	3,9	3,3	3,3	3,0
Хангайн бүс	32,2	31,9	21,1	22,6
Архангай	3,4	3,5	2,2	1,6
Баянхонгор	0,1	1,4	1,8	1,4
Булган	3,7	4,7	3,8	2,7
Орхон	12,0	9,8	4,4	5,9
Өвөрхангай	4,1	2,6	3,9	1,8
Хөвсгөл	8,9	10,0	4,9	9,1
Төвийн бүс	24,1	20,0	14,6	15,1
Говьсүмбэр	1,3	0,8	0,3	0,2
Дархан-Уул	6,3	4,3	3,4	5,4
Дорноговь	5,2	4,6	1,2	0,9
Дундговь	3,2	2,5	2,2	2,0
Өмнөговь	4,1	4,3	4,4	1,4
Сэлэнгэ	1,3	1,0	0,6	2,5
Төв	2,8	2,5	2,6	2,8
Зүүн бүс	7,0	8,4	9,5	9,7
Дорнод	0,6	3,2	3,1	2,2
Сүхбаатар	4,6	4,2	3,9	3,2
Хэнтий	1,7	1,0	2,5	4,2
Улаанбаатар	54,2	34,3	21,4	28,0

15- аас дээш насны, ажил хөдөлмөр эрхлээгүй, ажил хөдөлмөр эрхлэхэд бэлэн байсан, ХХҮХ-т бүртгүүлж болон бүртгэлгүйгээр ажил хайсан, ажил эрхлэх боломжтой 1,7 мянган эмэгтэйчүүд байна. Ажилгүй эмэгтэйчүүдийн тоо өмнөх оны мөн үеэс 0,6 мянган хүнээр буюу 26,1 хувиар буурсан байна. Мөн сүүлийн 3 жилийн дунджаас 32,0 хувиар буурчээ.

15 БА ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО,
 ҮҮНЭЭС ЭМЭГТЭЙ, бүс, аймаг, нийслэлээр, оны эцэст

Аймаг	мян. хүн			
	2009	2010	2011	2012
БҮГД	62,8	49,7	39,0	44,4
Баруун бүс	8,0	9,6	10,0	10,0
Баян-Өлгий	2,4	0,8	1,8	4,0
Говь-Алтай	1,0	1,1	1,4	2,0
Завхан	1,0	2,5	3,1	1,0
Увс	1,6	3,7	2,3	1,7
Ховд	2,2	1,5	1,3	1,2
Хангайн бүс	15,8	13,6	8,7	10,4
Архангай	1,7	1,8	1,0	0,9
Баянхонгор	0,1	0,3	0,5	0,6
Булган	1,9	2,0	1,4	1,1
Орхон	6,1	4,4	2,5	2,5
Өвөрхангай	2,0	1,2	1,5	1,2
Хөвсгөл	3,9	3,9	1,8	4,0
Төвийн бүс	9,9	8,2	6,0	6,7
Говьсүмбэр	0,3	0,2	0,1	0,0
Дархан-Уул	2,6	1,9	1,5	2,1
Дорноговь	2,4	1,7	0,5	0,4
Дундговь	1,3	0,9	0,8	0,1
Өмнөговь	1,6	1,8	1,4	0,4
Сэлэнгэ	0,6	0,4	0,2	1,5
Төв	1,0	1,1	1,5	1,2
Зүүн бүс	3,3	4,5	4,7	4,6
Дорнод	0,3	1,4	1,2	1,1
Сүхбаатар	2,4	2,5	2,3	1,5
Хэнтий	0,6	0,6	1,2	2,0
Улаанбаатар	25,8	13,9	9,5	12,7

Увс аймагт ажилгүйдлийн түвшин 2012 оны эцэст 8,4 хувьд хүрч улсын дунджаас 0,2 пунктээр их, баруун бүсийн дунджаас 1,4 пунктээр бага байна. Ажилгүйдлийн түвшингээр Баян-Өлгий, Говь –Алтай, аймгуудын дараа буюу бүсдээ 3 – д тооцогдож байна.

Ажилгүйдлийн түвшин сүүлийн 3 жил дараалан буурч байгаа бөгөөд 2010 онд хамгийн өндөр түвшинд буюу 15,0 хувьд хүрч байсан байна.


2012 оны ажилгүйдлийн түвшин сүүлийн 3 жилийн дунджаас 24,3 пунктээр бага байна. Ажилгүйдлийн түвшингээр 22 аймаг, хотоос 12-д тооцогдож байна.

АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН, бүс, аймаг, нийслэлээр

Аймаг	хувь			
	2009	2010	2011	2012
БҮГД	11,6	9,9	7,7	8,2
Баруун бүс	7,5	10,1	10,8	9,8
Баян-Өлгий	8,4	2,8	7,0	12,4
Говь-Алтай	6,6	9,0	10,8	13,7
Завхан	4,0	14,8	18,2	6,4
Увс	7,8	15,0	10,4	8,4
Ховд	9,6	9,2	8,6	8,0
Хангайн бүс	12,0	11,9	8,3	8,3
Архангай	7,2	7,0	4,5	3,3
Баянхонгор	0,3	3,6	5,0	3,6
Булган	13,3	15,2	13,4	9,1
Орхон	29,2	25,9	11,9	14,2
Өвөрхангай	7,1	4,9	8,2	3,4
Хөвсгөл	15,7	17,1	9,1	15,2
Төвийн бүс	11,2	9,3	6,8	7,7
Говьсүмбэр	21,2	14,3	4,8	6,1
Дархан-Уул	15,5	11,0	8,4	14,3
Дорноговь	20,7	15,8	5,5	3,8
Дундговь	13,3	10,1	8,8	8,5
Өмнөговь	15,0	15,4	15,3	6,5
Сэлэнгэ	2,5	2,1	1,4	6,0
Төв	6,5	6,0	5,5	5,9
Зүүн бүс	9,0	10,5	11,1	10,8
Дорнод	2,6	12,3	10,9	8,1
Сүхбаатар	15,9	13,8	13,7	10,7
Хэнтий	7,3	4,2	8,7	13,0
Улаанбаатар	14,0	8,7	5,6	7,1

Тус аймгийн ажилгүйдлийн түвшин өнгөрсөн 2011 оныхоос 2,0 пунктээр, 2010 оныхоос 6,6 пунктээр, бага, 2009 оныхоос 0,6 пунктээр илүү байна.

АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН, онуудаар, бүс, аймаг, улсын дундаж



Судалгааны дүнгээр Увс аймагт албан бус салбарт 11,3 мянган хүн ажиллаж байгаагийн 43,8 хувь буюу 4,9 мянган эмэгтэйчүүд ажиллаж байна. Эдгээр 11,3 мянган хүний 7,8 мянган нь буюу 69,0 хувь нь үндсэн ажил нь албан бус салбарт, 31,0 хувь нь давхар ажлаараа албан бус салбарт ажилладаг гэж тооцогдсон байна.

Албан бус салбарт ажиллагсадын тоо өнгөрсөн 2011 оноос 2,4 мянган хүнээр, харин эмэгтэйчүүд нь 1081 хүнээр тус тус өссөн байна.

Мөн үндсэн ажлаараа албан бус салбарт ажиллагсадын тоо 1378 хүнээр, давхар ажлаараа албан бус салбарт ажиллагсадын тоо 1019 хүнээр тус тус өссөн байна.

Албан бус сектор дахь ажиллагчдын тоо, аймаг, нийслэл, хүйсээр

Аймаг	Нийт			Үүнээс	
	Бүгд	Хүйсээр		Үндсэн	Давхар
		Эр	Эм		
БҮГД	174477	98175	76302	164874	9603
Баруун бүс	29279	16239	13040	25077	4202
Баян-Өлгий	5672	3698	1974	5275	397
Говь-Алтай	3183	1528	1655	3079	104
Завхан	4869	2215	2654	4755	114
Увс	11273	6333	4940	7781	3492
Ховд	4282	2465	1817	4187	95
Хангайн бүс	35688	20761	14927	33725	1963
Архангай	2967	1634	1333	2967	0
Баянхонгор	5242	3121	2121	4751	491
Булган	1851	1166	685	1599	252
Орхон	7321	3527	3794	6796	525
Өвөрхангай	10281	6262	4019	9586	695
Хөвсгөл	8026	5051	2975	8026	0
Төвийн бүс	25945	13947	11998	24556	1389
Говьсүмбэр	171	85	86,0	171	0
Дархан-Уул	7288	3290	3998	6846	442
Дорноговь	3790	2107	1683	3679	111
Дундговь	2099	1229	870	1789	310
Өмнөговь	1422	574	848	1422	0
Сэлэнгэ	6134	3577	2557	6075	59
Төв	5041	3085	1956	4574	467
Зүүн бүс	7024	3013	4011	6576	448
Дорнод	2023	740	1283	2023	0
Сүхбаатар	2470	972	1498	2313	157
Хэнтий	2531	1301	1230	2240	291
Улаанбаатар	76541	44215	32326	74940	1601

Ажиллагсадын тоог эдийн засгийн салбаруудаар, аймгуудаар гаргаагүй учир 2010 оны хүн амын тооллогын дүнгээс салбаруудаар гаргаж харууллаа.

АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМ,
ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАР, ХУВИАР 2010 ОН

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
		Эзлэх хувь	
Бүгд	100,0	100,0	100,0
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	51,8	54,3	48,7
Уул уурхай, олборлолт	1,3	2,0	0,5
Боловсруулах үйлдвэрлэл	4,6	3,7	5,7
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	0,8	1,2	0,4
Усан хангамж, бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	0,4	0,5	0,4
Барилга	2,5	3,5	1,2
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	6,5	5,2	8,1
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	3,5	5,9	0,4
Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	1,1	0,4	1,9
Мэдээлэл, холбоо	0,4	0,4	0,5
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	1,2	1,0	1,4
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	0,0	0,0	0,0
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	0,7	0,6	0,9
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	0,1	0,1	0,1
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	9,7	12,7	6,1
Боловсрол	10,0	5,4	15,7
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	3,6	1,5	6,1
Урлаг, үзвэр, тоглоом наадам	0,4	0,4	0,5
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	1,2	1,1	1,3
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	0,0	0,0	0,1
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	0,1	0,1	0,1

15 ба түүнээс дээш насны эдийн засгийн идэвхигүй хүн амын тоо 10,3 мянганд хүрч өнгөрсөн оноос 1,1 мянган хүнээр, сүүлийн 3 жилийн дунджаас 14,2 хувиар буурсан байна. Эдийн засгийн идэвхигүй хүн амын тоогоор баруун бүсдээ 4-д тооцогдож бүсийн нийт идэвхигүй хүн амын 16,3 хувь нь тус аймагт ноогдож байна.

15 БА ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХИГҮЙ
ХҮН АМЫН ТОО, бүс, аймаг, оны эцэст

Аймаг	МЯН. ХҮН			
	2009	2010	2011	2012
БҮГД	715,6	716,2	673,7	661
Баруун бүс	68,1	68,0	73,8	63,3
Баян-Өлгий	12,5	12,5	16,5	11,6
Говь-Алтай	7,1	7,3	7,4	7,2
Завхан	23,0	21,0	21,2	18,3
Увс	11,7	12,9	11,4	10,3
Ховд	13,9	14,3	17,3	15,8
Хангайн бүс	119,6	124,7	120,1	102,3
Архангай	14,3	13,4	11,7	11,3
Баянхонгор	17,2	17,7	16,0	13,8
Булган	19,1	15,6	10,6	13,1
Орхон	23,2	28,9	25,3	21,8
Өвөрхангай	20,3	22,1	26,9	17,6
Хөвсгөл	25,4	27,0	29,5	24,8
Төвийн бүс	111,1	101,0	88,2	102,8
Говьсүмбэр	4,2	4,2	3,1	3,5
Дархан-Уул	29,3	30,1	23,9	29,2
Дорноговь	14,2	11,0	14,5	13,1
Дундговь	10,7	9,2	7,5	7,5
Өмнөговь	15,6	11,6	9,3	12,8
Сэлэнгэ	23,4	19,7	17,6	21,8
Төв	13,8	15,2	12,4	15
Зүүн бүс	71,6	69,9	64,1	50,2
Дорнод	34,0	31,3	27,2	24,5
Сүхбаатар	12,5	10,8	10,7	8
Хэнтий	25,1	27,1	26,1	17,7
Улаанбаатар	345,3	353,3	327,4	342,4